

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА
Д.САРАНГАРАВ

Огноо: 2020.06.19

ЖАРГАЛАНТ, ГАЛУУТ СУМДАД АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНҮҮДИЙН
ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Гэрээний нэр, дугаар: Жаргалант, Галуут сумдад ариун цэврийн өрөөнүүдийн
засварын ажил:
БХАОНӨГ/202006131

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос багц1: Жаргалант сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний засварын ажил, багц2: Галуут сумын эруул мэндийн төвийн ариун цэврийн өрөөний бохирийн шугам, тоноглол хийх, худагт холбох инженерийн шугам сүлжээний ажил **БХАОНӨГ/2020006131-ыг гүйцэтгэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.meps.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 / тавин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн байх ёстой.**

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг төсөв, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг ТЭЗҮ-д хавсаргасан болно.

Үнийн саналыг [**2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 11 цаг**]-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [**2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн [11 цаг 10 минут]**]-д аймгийн Орон нутгийн өмчийн газрын 116 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцоно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар
(нэг давхарын 116 тоот өрөө, Орон нутгийн өмчийн газрын
мэргэжилтэн С.Рэнцэнбямбаас авах буюу, 70443224
88295091 утасаар холбогдоно.)**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|--|---|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч</p> <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> <p>3. Тендерийн иж бүрдэл</p> <p>4. Тендерийн үнэ</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>1.2. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.
Үүнд: <i>[БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхиевичийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт]</i></p> <p>1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: <i>Тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх машин, тоног төхөөрөмжийн жагсаалт, өөрийн эзэмшилийн болон түрээсээр эзэмшихийг нотлох баримтын хамт ирүүлэх.</i></p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маятуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчдод өгсэн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none">(а) Үнийн санал;(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл, түүний гэрээ, тэдгээрийг батлуулсан хуулбар;(д) Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заагдсан шаардлагатай бусад материалыг ирүүлэх. <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> <p>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болох ба энэ нь тодорхой үнэдслэлтэй байна.</p> <p>4.3. Тендерт оролцогч нь тухайн ажлын зураг болон техникийн</p> |
|--|---|

		тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарь, ажлын тоо хэмжээнд хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	4.4.	Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нэгж болон нийт үнэд багтаасан байна.
6. Алдааг залруулах	5.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	6.1.	Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна: (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дун хоорондоо зерсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ; (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна; (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	6.2.	Захиалагчийн залруулсан тендерийн дунг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дунг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2.	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
	8.1.	Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дун буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь бэлтгэж ирүүлэх ТББ, төсвийн тооцоондоо багц1: Жаргалант сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний засварын ажлын зураг төсөл зохиогчийн хяналтын зардал-1.718.085₮, багц2: Галуут сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний бохирийн шугам, тоноглол хийх, худагт холбох инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зохиогчийн хяналтын зардал-81.452 төгрөг болон бусад холбогдох хууль, журмын дагуу тооцогдох татвар хураамжуудыг бүрэн тооцон, дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ:</p> <p>Үүнд: 1. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: [БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт]</p> <p>БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхиевичийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт] /Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./</p> <p>2. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан, Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn-ээс тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</p> <p>3. Сүүлийн [2018, 2019 оны] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</p> <p>4. ТББ-т хавсаргасан жишиг маягтаар гаргаж баталгаажуулсан үнийн санал;</p> <p>5. Ажил гүйцэтгэх график ирүүлэх</p> <p>Жич: Тендерт оролцогч нь тухайн ажлын талбайтай танилцсан байх бөгөөд танилцсан талаарх мэдэгдлийг фото зургийн хамт ирүүлнэ.</p> <p>6. Улсын бүртгэлийн гэрчилгээний наториатаар баталуулсан хуулбар</p> <p>7. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны эсвэл арилжааны бүх банкнаас гаргасан зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт заавал ирүүлэх.</p> <p>8. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендерт оролцогчийн татварын өр, төлбөрийн талаарх мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгах тул өр, төлбөргүй байх шаардлагатай.</p> <p>9. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хучний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Удирдах болон инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, цахим үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрүүний хуулбар, мэргэжлийн үнэмлэхийн хуулбар ирүүлнэ. Нийгмийн даатгалын 2020 оны 05 сарын баталгаажсан НД-7, НД-8 маягтыг ирүүлнэ.</p> <p>10. Шүүхийн болон ШШГ байгууллагуудын хүчинтэй тодохойлолт</p> <p>11. Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж</p>

	<p>хэмжээ нь багц тус бүрийн батлагдсан нийт төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</p> <p>12. Сүүлийн 2 жил буюу зөвхөн 2018, 2019 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа багц тус бүрийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дунгийн 60 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй засвар угсралтын ажлын гэрээ байгуулж ерөнхий гүйцэтгэгчээр ажилласан байна. Өмнөх ажил гүйцэтгэсэн гэрээ, хүлээлгэж өгсөн улсын комиссын акт, захиалагчийн тодорхойлолт эсвэл захиалагчийн дүгнэлтийг ирүүлнэ. Ажлын явц нь 70-иас дээш хувийн гүйцэтгэлтэй, сүүлийн 2 жилд хамаарах засвар угсралтын ажлыг ижил төстэй ажилд тооцон үзнэ. Тухайн 70-иас дээш хувийн гүйцэтгэлтэй засвар угсралтын ажлын гэрээ, ажлын явцын талаарх захиалагчийн тодорхойлолт, засвар угсралтын ажлын явцыг баталгаажуулсан фото зургуудыг ирүүлэх шаардлагатай.</p> <p>14. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Багц тус бүрийн батлагдсан нийт төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын дансны үлдэгдэл харилцагч банкны тодорхойлтоор /Хувь хүний нэр дээрх буюу захирлын нэр дээрх дансны үлдэгдлийг тооцохгүй/ -Арилжааны банкны зээлийн тодорхойлолтыг тус тус тооцно /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой эсхүл шаардлагатай баримт материалыг үндэслэн гэх тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй судлагдсан тодорхойлолт байх/ <p>15.Тухайн ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх машин, тоног төхөөрөмжийн жагсаалт, өөрийн эзэмшилийн болон түрээсээр эзэмшихийг нотлох баримтын хамт ирүүлэх.</p> <p>16. Тендерт оролцогч нь тухайн тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлуудыг гүйцэтгэн, дуусгаж ашиглалтанд хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>Жич: Санхүүжилтийн эх үүсвэр нь: Орон нутгийн иргэдээд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ" төслийн санхүүжилтээр багц1: Жаргалант сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний засварын ажил-45.100.000 төгрөг, багц2: Галуут сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний бохирийн шугам, тоноглол хийх, худагт холбох инженерийн шугам сүлжээний ажил-15.700.000 төгрөгөөр 2020 онд тус тус санхүүжигдэнэ.</p>
--	--

Нийт: 60.800.000 ₮

A. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- | | |
|--|--|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. |

ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн сервирин цагаар тооцогдох тул хугацаас хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Огноо: 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 11 цаг 00 минут
ТОӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Давхар болон өрөөний дугаар: / Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нэг давхарын 116 тоот өрөө. Огноо: 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн Цаг: [11 цаг 10 минут]

- | | |
|--|---|
| | <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> |
| 5. Зааварчилгаа | <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.</p> |
| 6. Маргааныг шийдвэрлэх | <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> |
| Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ | |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> |
| 9. Зөрчил, гологдол арилгах | <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> |
| 11. Үе шатны ажлын хуваарыг¹ | <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | <p>B. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</p> <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваары дахь үнийг өөрчлөхгүй.</p> |

13. Алданги	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
14. Ажил дуусгах	Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ
15. Хүлээж авах	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч хэвлэгдэх товхимолд тавигдах техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг бүрэн хангаж, хэвлэх ажлын явцад гарсан алдаа зөрчлийг бүрэн хэмжээгээр арилгасан байна.
16. Эцсийн тооцоо	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлагы	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ируулсан тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ируулсан эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
18. Гэрээг цуцлах	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
	17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
	18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
	18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
	(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
	(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
	(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
	(г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
	(д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид

		мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
	(e)	гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
18.	Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
19.	Гэрээг цуцалсан үед хийх төлбөр	19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгээс захиалагчид төлөх ёстой өр болно.
20.	Гүйцэтгэлээс чөлөөлөх	19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
		20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 2.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: багц1: Жаргалант сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний засварын ажил, багц2: Галуут сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний бохирийн шугам, тоноглол хийх, худагт холбох инженерийн шугам сүлжээний ажил /БХАОНӨГ/202006131/
- 2.1 Ажил нь: Багц1:Баянхонгор аймгийн Жаргалант сумын дотуур байрны ариун цэврийн өрөөний засварын ажил, багц2: Галуут сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн өрөөний бохирийн шугам, тоноглол хийх, худагт холбох инженерийн шугам сүлжээний ажил, түүнтэй холбогдох ажлын зураг, төсөв хавсралтуудаас бүрдэнэ.
- 3.1 Төслийн менежер нь: Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Д.Ихбаяр
- 4.1 Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулагдсан өдрөөс.
Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор гүйцэтгэж аймгийн ЗДТГ-с томилсон комисст хүлээлгэн өгсөн байх.
- 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 6 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 9.1 Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
- 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
17.1 Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2020 оны 08 дугаар сарын 25-ны

дотор гаргаж өгнө.

Гүйцэтгэлийн зургийг 2020 оны 08 дугаар сарын 25-ны дотор гаргаж өгнө.

Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ 100.000 төгрөг байна.

- 19.1 Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0-иар тооцно.

Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц тус бүрийн техникийн тодорхойлолт, ажлын зураг төсөв бусад холбогдох бүх материалыг tender.gov.mn цахим системийн ТЭЗҮ-д хавсаргав.

Зургаа. ЗУРАГ

Зургийн санамж

Багц тус бүрийн ажлын тоо хэмжээ, зураг төсвийг tender.gov.mn цахим системийн ТЭЗҮ-д т хавсаргав. Тендерт оролцогчид нь ажлын зургийн дагуу байршилуудыг газар дээр нь үзэж, ажлын зургуудыг гаргаж үнийн саналд хавсарган ирүүлнэ.

Долоо. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарийг: Тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаарлагатай бөгөөд үүнийг гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээ ба гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэнэ.

Найм. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [30] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулхтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид "ажил" гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс :

Улсын төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 200.... онд: _____ төгрөг; 200.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____

оны __ дугаар сарын __-ны өдөр эхэлж, ____ оны __ дугаар сарын __-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3 Үнийн санал
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт;
- 5.7 Зураг;
- 5.8 Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9 Санхүүжилтийн хуваарь;
- 5.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцуулэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]